



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/343

Чингис хот

Гэр бүлийн хэрэгцээнд дундаа
хамтран өмчилсөн газрыг гэр бүлийн нэг
гишүүнд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 7 дугаар зүйлийн 7.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Аймгийн Засаг даргын 2006 оны 27, 197 дугаар захирамжийн 59, 28, 2008 оны 32 дугаар захирамжийн 70, 71 дэх хэсгээр тус тус гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран өмчилсөн иргэдийн өмчлөх эрх шилжүүлэх гэрээ болон бусад холбогдох бичиг баримтыг харгалзан хавсралтад дурдсан нэр бүхий иргэдэд үнэ төлбөргүй шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Газар өмчлөгч иргэдийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хэрлэн сумын Засаг даргын орлогч /М.Шүрэнцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг 2006 оны 27, 197 дугаар захирамжийн 59, 28, 2008 оны 32 дугаар захирамжийн 70, 71 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Хавсралтад дурдсан нэр бүхий иргэдэд хууль тогтоомжийн дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

08 Аймгийн Засаг даргын 2020 оны
 дугаар сарын 12 өдрийн 13/2020
 дугаар захирамжийн хавсралт



№	Өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа иргэний				Хамтран өмчлөлөөс хасуулж, өмчлөх эрх нь сэргэж байгаа иргэний				Захирамжийн		Хуучин нэгж талбарын дугаар	Газрын Байршил	Хэмжээ /м2/
	Ургийн овог	Овог	Нэр	Регистрийн дугаар	Ургийн овог	Овог	Нэр	Регистрийн дугаар	Огноо	Дугаар			
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	Ниндэв	Яринпил	Бираа	СЭ48090475	Оожин	Гомбожав	Оюунцэцэг	СЭ61062863	2006.08.16	197	221602336	1-р баг Хийд 14-03 тоот	664
					Ниндэв	Бира	Алтантуяа	СЭ86081467					
					Ниндэв	Бира	Банзрагч	СЭ93050911					
2	Жаал	Жанчив	Гонгор	СЮ45081035	Завъяа	Гомбосүрэн	Ичинноров	СЮ47080106	2008-02-19	32	221603502	4-р баг Цацал 7-08 тоот	700
3	Боржигин	Гомбожав	Алтанцэцэг	СЮ63121669	Боржигин	Алтанцэцэг	Болорсайхан	СЮ86120267	2006-02-20	27	221600738	4-р баг Эрчим 40-20 тоот	414
4	Жаал жанчив	Гонгор	Лувсангомбо	СЮ77071032	Боржигон	Агваан	Нандинцэцэг	СА80051205	2008-02-19	32	221603501	4-р баг Цацал 6-08 тоот	700